

Бүх асуулт : 20

1 Хүний нүдний бүтцийн ойлголтуудыг зөв өгөгдөлтэй нь харгалзуулна уу?

a) Болор b) Нулимсан бүрхүүл c) Харааны мэдрэл	1	Ойр байгаа юмсын фокусыг зургийн аппарат шиг тохируулаад торлог бүрхэвч рүү дамжуулна.
	2	Торлогоос ирсэн мэдээллийг тархинд өнгө, дүрс байдлаар дамжуулна.
	3	Гэрэл эцэст нь нүдний хамгийн дотор талын нимгэн хальс торлогт нэвтэрч харааны мэдрэл үү дамжина.
	4	Гэрэл тусах хамгийн эхний давхарга бөгөөд үүний ачаар бид гэрлийн цацрагийг мэдэрнэ.

- ☐ A a2b4c3
☐ B a2b3c1
☒ C a1b4c2
☐ D a1b2c4

Зөв хариулт

a1b4c2

2 Чихний тухай ойлголтуудыг зөв өгөгдөлтэй нь харгалзуулна уу?

a) Хэнгэрэг b) Сонсголын суваг c) Чихний дун	1	Дуу чимээг боловсруулна. Тэнцвэрээ олоход тусална. Маш эмзэг
	2	Чимээ сонсогдоход чичирхийлдэг маш нимгэн хальсан эд
	3	Хэнгэрэг чичирхийлэхэд доргиж, чичиргээг цааш дамжуулна.
	4	Чихнээс хоолой руу очно. Чихэнд даралт ирэхээс сэргийлдэг.
	5	Чимээг цуглуулж, чихний сувгаар нэвтрүүлнэ. Энэ нь зөөлөн мөгөөрснөөс бүтнэ.

- ☐ A a2b4c3
☒ B a2b4c1
☐ C a5b3c2
☐ D a1b2c4

Зөв хариулт

a2b4c1

3 “Дунд тархин”-д явагддаг үйлдлүүдийн жишээнүүдийг олоорой.

1. Хэн нэгэн таны зөвшөөрөлгүйгээр хувийн зүйлсийг чинь авч хэрэглэсэн байгааг мэдээд бухимдах.
2. Сурагч “Т” ангийнхаа сурагчдаас хамгийн зөв цэгцтэй ярьдаг бөгөөд санаа бодлоо илэрхийлэхдээ сул үг хэрэглэдэггүй.
3. Анх удаа олон хүний өмнө тайзан дээр гарч үг хэлэхийн өмнө гар нь чичирч, зүрх нь хурдан цохилж эхлэх.
4. Та амьдарч байсан газар, эсвэл өнгөрсөн хугацаандаа чухал байсан зүйлсээ алдсан үед уйтгар гуниг төрдөг.
5. Дүүгийнхээ “математик”-ын гэрийн даалгаврыг хийхэд тусалж, бодлого бодох аргачлалыг нь зааж өгөх.

- ☒ А 1, 3, 4
- ☐ В 3, 4, 5
- ☐ С 1, 2, 5
- ☐ D 1, 2, 4

Зөв хариулт

1, 3, 4

4 “Үндсэндээ хүмүүс юмны амтыг амаараа мэдрч байна гэж боддог, гэвч зарим тохиолдолд амт мэдрэгдэж байгаа нь бидний хамартай холбоотой байдаг.” гэсэн нь хэний үзэл баримтлал вэ?

- ☐ А Аризонагийн их сургуулийн хэл шинжлэл, философийн профессор Ноам Чомски
- ☒ В Филадельфийн их сургуулийн чих, хамар судлалын ухааны профессор Б.Коварт
- ☐ С Харвардын их сургуулийн философи, шашин судлалын профессор Корнел Уэст
- ☐ D Нью-Йоркийн их сургуулийн эдийн засгийн профессор Пол Кругман

Зөв хариулт

Филадельфийн их сургуулийн чих, хамар судлалын ухааны профессор Б.Коварт

5 Цэлийн оронд тохирох ойлголтыг сонгоорой.

Хэлэн дээр байдаг өчүүхэн жижиг товгор зүйлс бол амт мэдрэгч буюу гэдэг.

- ☐ А мэдрэл
- ☐ В болор
- ☐ С солонгон бүрхэвч
- ☒ D хөхлөгүүд

Зөв хариулт

хөхлөгүүд

6 Аль дасгалын тусламжтайгаар уушгины үйл ажиллагаа сайжирч, цусны эргэлтийг болон хийн солилцоог сайжруулдаг вэ?

- ☒ А Амьсгалын дасгал
- ☐ В Чихний тэнцвэрийн дасгал
- ☐ С Нүдний ядаргааг тайлах дасгал
- ☐ D Гарын дасгал

Зөв хариулт

Амьсгалын дасгал

7 Зорилготой хүний үйлдэлд аль нь хамаарах вэ?

- ☐ А Бусдаас бүрэн хамааралтай байх
- ☐ В Санал асуулт, шүүмжлэлд нээлттэй
- ☐ С Бусдын буруу ятгалгад амархан автах
- ☐ D Богинохон хугацаанд хэтэрхий олон зүйлсийг оролдож үзээд хаях

Зөв хариулт

Санал асуулт, шүүмжлэлд нээлттэй

8 Дараах үгсийг тайлбартай нь зөв тохируулна уу?

a) Бага тархи b) Дунд тархи c) Их тархи	1	Амьсгалах, тэнцвэр олох гэх мэт үйлдэл хариуцдаг
	2	Сэтгэн бодох, төлөвлөх, логик сэтгэлгээ гэх мэтийг удирддаг
	3	Сэтгэл хөдлөл, санах ойн үйлдлүүд явагдана.
	4	Баяр баясал, уур бухимдал, уйтгар гуниг, айдас түгшүүр

- ☐ А a-1; b-4; c-2,3
- ☐ В a-4; b-1; c-2,3
- ☐ С a-1; b-3,4; c-2
- ☐ D a-2; b-3,4; c-1

Зөв хариулт

a-1; b-3,4; c-2

9 Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой.

Хэлний хэсгүүд цочрох үед юм.

- ☐ А Зөвхөн гашуун амтыг мэдрдэг
- ☐ В Зөвхөн чихэрлэг амтыг мэдрдэг
- ☐ С Зөвхөн исгэлэн амтыг мэдрдэг
- ☐ D өөр өөр амтыг мэдрдэг

Зөв хариулт

өөр өөр амтыг мэдрдэг

10 Өдрийн тэмдэглэл хөтлөхийн давуу талд хамаарахгүй олоорой.

- ☐ А Тэмдэглэл хөтлөх нь таны бодол, үйлдлийг эргэцүүлж, өөрийгөө илүү сайн ойлгох боломжийг олгодог. Энэ нь хувийн хөгжилд чухал ач холбогдолтой.
- ☐ В Өдөр тутмын сэтгэл санаа, мэдрэмжүүдийг хэт олон удаа тэмдэглэх нь сэтгэл зүйн ачаалал үүсгэж, сөрөг мэдрэмжүүдийг дахин бодоход хүргэж болзошгүй.
- ☐ С Тэмдэглэл хөтлөх нь зорилгоо тодорхойлох, хийгдэх ажлуудыг дараалалтайгаар бичихэд тусалж, илүү бүтээмжтэй ажиллахад үр дүнтэй байдаг.
- ☐ D Өдөр тутмын тэмдэглэл нь таны үйлдлүүд, амжилт болон алдааг хянах боломжийг олгодог. Энэ нь дараагийн удаа илүү сайн шийдвэр гаргахад тусална.

Зөв хариулт

Өдөр тутмын сэтгэл санаа, мэдрэмжүүдийг хэт олон удаа тэмдэглэх нь сэтгэл зүйн ачаалал үүсгэж, сөрөг мэдрэмжүүдийг дахин бодоход хүргэж болзошгүй.

11 Багш болон шавийн харилцаанд анхаарах зүйлсэд хамгааралгүй зүйл дурдсаныг олоорой.

- ☐ А Өөрийн мэдлэг, туршлагаа хэт үнэлэх
- ☐ В Практик туршлага дээр суурилсан хичээл
- ☐ С Өөрийн сэтгэхүйг хөгжүүлэх боломжийг олгох
- ☐ D Асуулт асуух, харилцан идэвхтэй оролцуулах

Зөв хариулт

Өөрийн мэдлэг, туршлагаа хэт үнэлэх

12 Шүүмжлэлийг сонсож хүлээж авч сурах үйлд аль нь хамгаарахгүй вэ?

- ☐ А Анхааралтай сонсож ойлгох
- ☐ В Үгийн утгыг ойлгох, тунгаан бодох
- ☐ C Хэтэрхий их сэтгэл хөдлөлд автах
- ☐ D Миний төлөө хэлж байгаа гэж ухаарах

Зөв хариулт

Хэтэрхий их сэтгэл хөдлөлд автах

13 Дараах ойлголтуудын аль нь "Гэрээ засаад төрөө зас" гэдэг зүйр үгийг бүрэн илэрхийлж байна вэ?

- ☐ А Биелүүлж чадах амлалтаас эхэлж зорилго тавих ёстой байдаг
- ☐ В Өөрийнхөө өмнө сайн сайхан үйл бүтээж зорилго тавьж, хэрэгжүүл
- ☒ C Чи амьдралаа өөрчлөхийг хүсвэл өөрөөсөө л эхлэх хэрэгтэй
- ☐ D Өөрийнхөө алдааг засахаасаа өмнө бусдын алдааг засах ёстой

Зөв хариулт

Чи амьдралаа өөрчлөхийг хүсвэл өөрөөсөө л эхлэх хэрэгтэй

14 Дараах бодомжуудын аль нь зөв бэ?

- ☐ А Өөрийн эрх, эрх чөлөөг эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөөнд халдаж болохгүй
- ☐ В Өөрийн эрх, эрх чөлөөг эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөөнд хүндэтгэлгүй хандах
- ☐ C Өөрийн эрх, эрх чөлөөг эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно
- ☐ D Өөрийн эрх, эрх чөлөөг эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөөнд хасаж болно

Зөв хариулт

Өөрийн эрх, эрх чөлөөг эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөөнд халдаж болохгүй

15 Багш сурагчдаас судалгаа авахаасаа өмнө судалгааны зорилгыг танилцуулж, ямар үйл ажиллагаанд ашиглах гэж байгаа тухай чиглүүлэг өгсөн. Тиймээс та судалгаа авах гэж байгаа багшаас асуулт асуумаар байвал дараах үйлдлүүдийн алийг нь хийвэл тохиромжтой гэж бодож байна вэ?

- ☐ А Багшийн хэлсэн үгийг хүлээж дуусгалгүй өөрийн санаа бодлоо шууд хэлж судалгаанд оролцох эсэхээ хэлэх.
- ☐ В Өөрийн бодлыг зөвхөн илэрхийлэхэд анхаарал хандуулах, багшийн хэлж байгаа зүйлийг үл тоомсорлох.
- ☐ C Багшийн хэлсэн үгийг хүлээхгүй, хурдан шийдвэр гаргаж судалгааг аль болох хурдан бөглөж дуусгах.
- ☐ D Багшийн хэлсэн үгийг ярьж (судалгааны тухай) дуусах хүртэл хүлээж, дараа нь өөрийн бодлоо илэрхийлэх.

Зөв хариулт

Багшийн хэлсэн үгийг ярьж (судалгааны тухай) дуусах хүртэл хүлээж, дараа нь өөрийн бодлоо илэрхийлэх.

16 Гэр бүлийнхнээ хүндлэх үйлдэлд аль нь хамаарахгүй вэ?

- ☐ А Хүүхдийнхээ санаа бодлыг амжилттай хэрэгжүүлэхэд туслахын тулд түүний санал бодлыг сонсож, хүлээн зөвшөөрөх.
- ☐ В Гэр бүлийн гишүүдтэй хэлэлцэх үед уурлаж, бухимдаж байгаа ч гэсэн үг хэлэхдээ хянамгай байж, бие биеэ доромжлохгүй байх.
- ☐ С Гэр бүлийн гишүүдийн хувийн орон зайг хүндэтгэж, тэдний амар тайван байдлыг алдагдуулахгүй байх.
- ☐ D Гэр бүлийн гишүүдийн хувийн орон зайд нь орж, хувийн амьдралд нь хэтэрхий оролцох.

Зөв хариулт

Гэр бүлийн гишүүдийн хувийн орон зайд нь орж, хувийн амьдралд нь хэтэрхий оролцох.

17 Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой.

Чингис хаан өөрийг нь харваж шархтуулсан ч үнэнээ хүлээсэн Зургаадгийн байдаг.

- ☐ А шударга занг үнэлж Зөв гэж нэрлэж, түүнтэй нөхөрлөсөн
- ☐ В төрийн эсрэг үйлдэл хийсэн хэмээн газар нутгаасаа хөөн гаргасан
- ☐ С шударга занг үнэлж, түүний "таван хуруу"гийн шийтгэл оногдуулсан
- ☐ D эзэн рүүгээ сум харвасан хэмээн цаазаар авах шийтгэл оногдуулсан

Зөв хариулт

шударга занг үнэлж Зөв гэж нэрлэж, түүнтэй нөхөрлөсөн

18 Дараах ойлголтуудыг тохирох үетэй нь зөв харгалзуулаарай.

a) Нүүрэн дээр нь хэлэх	1 Нүүр нүүрээ харж байгаад бурууг нь хэлэх
b) Улаан нүүрэн дээр нь улайтал хэлэх	2 Зэмлэн буруушаах, бурууг хэлэх
c) Дэгсдүүлэх	3 Бодит байдлаас хэтрүүлэн ярих, цаашлуулах
	4 Алдаа дутагдлыг нь ил тодоор өөрт нь хэлэх
	5 Сонсомгүй зүйлийг дахин давтан ярих, хэлэх

- ☐ А a2b1c4
- ☐ В a1b3c5
- ☐ С a4b3c5
- ☒ D a4b1c2

Зөв хариулт

a4b1c2

19 Эерэг харилцааны шинжид аль нь хамаарах вэ?

- ☐ А Хоёр тал харилцаандаа цаг завшаа зориулахгүй, нэгнийхээ хэрэгцээг үл тоомсорлох.
- ☐ В Хоёр талын хооронд байнга зөрчилдөөн үүсэж, бага зэргийн асуудал ч томоохон маргаан, хэцүү байдалд хүргэдэг.
- ☒ С Ямар ч сэтгэл санааны бэрхшээлгүй, эвтэй найртай ярилцаж, нэгнийхээ санаа бодлыг сонсох.
- ☐ D Хоёр хүн бие бие рүү итгэлгүй, эргэлзэж, зөрчилдөөн үүсэхээс сэргийлэх оролдлого багатай байдаг.

Зөв хариулт

Ямар ч сэтгэл санааны бэрхшээлгүй, эвтэй найртай ярилцаж, нэгнийхээ санаа бодлыг сонсох.

20 Дараах өгөгдлүүдийг ажиглаад сэтгэл, бие, хэлээр үйлдэх үйлдлүүдийг хүснэгтэд зөв ялгаарай.

1. Хүмүүст хэлсэн доромжлол, муу үгс (худал ярих, хов зөөх, ширүүн үг хэлэх) нь харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг.
2. Замын хөдөлгөөнд хурд хэтрүүлж, анхааралгүй явснаар осол гарах эрсдэл нэмэгдэж, өөрөө болон бусдад хохирол учруулж болно.
3. Өөртөө итгэлгүй байдлаас болж бусдыг доромжлох нь дарамт үүсгэж, харилцааг эвдэж болзошгүй.
4. Ачааг хэт их ачаалалтай өргөх нь бие махбодод хүнд ачаалал өгч, аюултай гэмтэлд (нуруу, үе мөч гэх мэт) хүргэж болох юм.

Сэтгэлээр үйлдэж буй үйлдэл	Биеэр үйлдэж буй үйлдэл	Хэлээр үйлдэж буй үйлдэл
a)	b)	c)

- ☐ A a-4; b-2; c-1,3
☐ B a-4; b-2,3; c-1
☐ C a-2; b-3,4; c-1
☐ D a-3; b-2,4; c-1

Зөв хариулт

a-3; b-2,4; c-1